

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ЯАМНААС 2009 ОНЫ 09 ДУГААР САРД  
ХИЙСЭН ГОЛ АЖИЛ**

**Нэг. Бодлого төлөвлөлтийн асуудлаар:**

**1. Улсын Их Хурал болон Байнгын хороодын хурлаар хэлэлцүүлсэн асуудал:**

- Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороонд Мал эмнэлэг үржлийн чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл бэлтгэж хүргүүлэв.

**2. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудал:**

- Салбарын 2010 оны төсвийн төлөвлөгөөг Сангийн яам, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороогоор хянуулан тохиролцож Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.
- 2010-2012 оны үндсэн чиглэлийн төслийг Сангийн яам, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороогоор хянуулан тохиролцож Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.
- Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төслийг холбогдох яамдаас санал авч, 9 дүгээр сарын 30-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.
- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийг 2009-2010 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газрын 2009 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 280 дугаар тогтоолоор батлууллаа.

**3. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудлууд:**

- Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөлийн хуралдаанаар 2010 оны төсвийн төсөөлөл, Үтрэм, элеваторын аттестатчилал, “Францын Хүнсний тусламжийн сангийн 2003-2008 оны үйл ажиллагаа”-ний хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан тооллогын дүнгийн тухай, “Мал аж ахуй, газар тариалан хосолсон загвар аж ахуйн хөгжлийг дэмжих” төслийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, “Агропарк” төслийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, “Усны үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд бэлчээрийн усжуулалтын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангуудыг хэлэлцэж холбогдох зөвлөмж, тэмдэглэлүүдийг гаргав.

**4. Судалж, боловсруулсан асуудлын талаар:**

- “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн төслийг УИХ-ын дэргэдэх ажлын хэсэгт танилцуулахаар бэлтгэлээ. Хуулийн төсөл Эдийн засгийн байнгын хорооны хурлаар 11 дүгээр сард хэлэлцэхээр тов тогтов.
- Ноос, ноолуур, арьс шир, оёдол, модны салбарт мөрдөгдөж байгаа стандартуудыг дахин хянах, шинэчлэхээр холбогдох стандартчиллын техникийн дэд хороонуудад ажиллаж байна. Арьс ширний үйлдвэрийн салбарт одоо мөрдөгдөж байгаа түүхий эд бэлтгэл, анхан шатны боловсруулалт хийсэн арьс ширний 2 стандартыг дахин хянаж, боловсруулсан үслэг, илгэн нэхийний 2 стандартыг шинээр боловсруулж Арьс ширний стандартчиллын техникийн дэд хороогоор, хивсний үйлдвэрлэлийн 13 стандартыг шинэчлэх төсөлд санал өгч ноосны стандартын Техникийн дэд хорооны хурлаар тус тус хэлэлцүүлэв.
- “Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих” хөтөлбөрийн Үндэсний зөвлөлийг ХХААХҮ-ийн Сайдын 2009 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 222 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд хөтөлбөрийг 2012 он хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.
- “Сүү” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэж, 9 дүгээр сарын 15-ны өдрийн Сайдын 221 дүгээр тушаалаар батлуулав.

- “Бараа түүхий эдийн биржийн тухай хууль”-ийн төсөлд яамдаас санал авч нэгтгэн Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээр бэлтгээд байна
- “Хүнсний тухай” хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг ХЗДХ-ийн Сайдаар батлуулахаар бэлтгээд байна.
- “Мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжийг дэмжих” хөтөлбөрийн төслийг боловсруулж, сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгов.
- Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг ажлын хэсгээс холбогдох яамд, салбарын мэргэжлийн холбоод, үйлдвэрлэгчидтэй хамтран “Барааг тодорхойлох, кодлох, уялдуулсан систем”-ийн дагуу гарган, “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг ЗГХЭГТ-т хүргүүлэхээр бэлтгэж байна.
- “Арьс ширний салбарын тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийн төслийг Монголын арьс шир үйлдвэрлэгчдийн холбоогоор хэлэлцүүлэв.
- Монголын инженерүүдийн анхдугаар зөвлөлгөөн зохион байгуулахаар Мэргэжлийн 30 Холбоонд албан бичиг явуулж, хамтран ажиллах “Ажлын хэсэг” байгуулах тушаалын төсөл боловсруулсан. Зөвлөлгөөний хөтөлбөр, ажлын төлөвлөгөө, зардлын урьдчилсан төсвийн төсөл боловсруулав.

### **Хоёр. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудлаар:**

- Улсын ургацын комиссын гишүүдийг Сайдын 198 дугаар тушаалаар томилуулж, хурлыг 09 сарын 1-ний өдөр зохион байгуулж, ургац хураалтын бэлтгэл ажлын тухай Сэлэнгэ, Төв аймгийн засаг дарга нарын илтгэлийг сонсож гишүүдээс гаргасан саналын дагуу аймаг орон нутагт Сайдын албан даалгаврыг хүргүүлэн хэрэгжилтэнд нь хяналт тавьж мэдээ мэдээлэл арга зүйгээр ханган ажиллаж байна. Сэлэнгэ, Төв, Булган, Хөвсгөл, Орхон аймгуудад улсын ургацын комиссын гишүүд болон УИХ-ын дарга, Ерөнхий сайд ажиллахад мэдээ, мэдээлэл өгч ажиллав.
- Ургацын төв штабыг Сайдын 215 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Ургац хураалтанд зориулж 6.0 мянган тонн шатахууны хуваарийг хийж, Сайдын 216 дугаараар батлуулж, аж ахуйн нэгжид олгох хэрэгжилтийг зохион байгуулж байна.
- ОХУ-ын Ростсельмаш үйлдвэрээс 40 ширхэг НИВА эффект комбайн ирснийг 30 ширхэгийг аж ахуйн нэгжүүдэд, 10-г Сэлэнгэ аймгийн ТӨҮГ-дад хурдан шуурхай хүлээлгэн өгч хураалтанд гаргасан. Энэ сарын 18-20-ны өдрүүдэд орсон цасны улмаас налсан тариа хураах иш өргөгч тоног төхөөрөмжийг 7000 ширхэгийг ОХУ-аас авах талаар хөөцөлдөж, оруулж ирэв. Эдгээрийг аж ахуйн нэгжүүдэд олгож байна. Тендерээр нийлүүлэгдэх JONN DEERE -1076 комбайн 10 ширхэг ирсэнийг хүлээн авч хувиарлаж хураалтанд гаргалаа.
- Улсын хэмжээнд байгаа үтрэм, элеватор будааны агуулахуудын тооллого явуулж нэгдсэн дүнг 09 сарын 1-ний өдрийн Сайдын зөвлөлийн хуралд танилцуулав. Тооллогоор тариалангийн бүс нутгийн 8 аймаг, нийслэл, 43 сум, 224 аж ахуйн нэгжийн 200 үтрэм, 118 агуулах, 22 элеватор хамрагдсан байна. Нийт 200 үтрэмд 152.2 га талбай ашиглагдаж байгаагийн 112 үтрэмд хамаарах 88.9 га талбай нь шороон гадаргуутай, 88 үтрэмд хамаарах 32.8 га талбай нь цементэн гадаргуутай байна. Хүнсний буудай хадгалах 333800 тонн багтаамжтай 22 элеватор тоологдсон байна. Элеватор, гурилын үйлдвэрүүдэд хуваарилах буудайн тоо хэмжээг аж ахуйн нэгж бүрээр гаргах тооцоог урьдчилан хийв.
- Монгол Улсын Засгийн газрын “Өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 2009 оны 221 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гантай болон гандуу аймгийн нутаг бэлчээрт гангийн зэрэглэл тогтоох, орон нутгаас тавьсан зарим асуудлыг шуурхай шийдвэрлэх зорилгоор Засгийн газрын ажлын хэсэг гарч Дундговь, Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай, Завхан аймагт ажиллаа. Ажлын хэсгийг орон нутагт ажиллах явцад гантай болон гандуу аймгуудын бэлчээрийн даац багтаамж хүрэлцээгүйн улмаас зарим тусгай хамгаалалттай газар нутгуудад түр хугацаагаар тодорхой тооны өрх, малыг оруулж өвөлжүүлж, хаваржуулах талаар нэгдсэн шийдвэр гаргуулах саналыг тавьсаны дагуу манай яам болон Засгийн газрын ажлын хэсэг судлан үзээд Улсын тусгай хамгаалалттай газар, Улсын хилийн зурвас газар түр хугацаагаар оруулж өвөлжүүлж хаваржуулах өрх, малын судалгааг гаргаж холбогдох газруудад хүргүүлээд байна. Улсын тусгай хамгаалалттай газар 1120.0 мянга, Хилийн зурвас газар 960.0 мянган толгой мал тус тус өвөлжүүлж, хаваржуулах асуудлыг холбогдох яамдуудтай хамтран шийдвэрлэх арга

- хэмжээ аваад байна. Хадлан тэжээл бэлтгэх ажил 9 дүгээр сарын 28 – ны байдлаар өвс 727.3 тн буюу 72.3 хувь, гар тэжээл 23.3 тн буюу 57 хувьтай байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал хадлан 170.0 тн, гар тэжээл 9.0 тн – р илүү байна.
- Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь аймгийн удирдлагаас гангийн зэрэглэл тогтоож, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан асуудлуудыг судлаж шийдвэрлүүлэх чиглэлээр ажлын хэсгийг орон нутагт ажиллуулах хүсэлтийг Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд ирүүлсний дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2009 оны 184 дүгээр тушаалаар дээрх аймгуудын зуншлагын байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, гангийн зэрэглэл тогтоох ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Онцгой байдлын ерөнхий газар, Цаг уур, орчны шинжилгээний газрын холбогдох мэргэжлийн хүмүүсийн оролцоотойгоор байгуулан орон нутагт ажиллав. Ажлын хэсэг 2009 оны 9 дүгээр сарын 03-17-ны хооронд гантай буюу гандуу байгаа Дундговь аймгийн 5 сум, Өмнөговь аймгийн 6 сум, Өвөрхангай аймгийн 8 сум, Баянхонгор аймгийн 6 сум, Говь-Алтай аймгийн 9 сум нийт 5 аймгийн 34 сумын нутгаар явж гангийн байдлыг тогтоож сум, орон нутгийн удирдлага, холбогдох байгууллага, иргэд малчидаас тавьсан хүсэлтийг судлан үзэж шийдвэрлэх арга хэмжээний талаар асуудал боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулж отрын нөөц газруудад шинээр худаг, уст цэг гаргах, аймаг, сумдын улсын нөөцийн цэг салбаруудад байх өвс, тэжээлийн тоо, хэмжээг нэмэгдүүлэхэд шаардагдах тээврийн зардал, отор нүүдэл хийж байгаа малчдад эрүүл мэнд, нийгэм, төрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан орон нутгийн захиргааны байгууллагуудад гарах тээвэр, шатахуун, үйлчилгээний нэмэлт зардал зэрэгт шаардагдах нийт 751,2 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлэсэн Засгийн газрын 296 дугаар тогтоол гаргуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна.
  - Монголын Бэлчээрийн менежментийн холбоотой хамтран Хэрлэнбаян-Улаан, Багахайрхан, Аргалант, Малахын аймаг дундын отрын бүс нутгуудад бэлчээрийн мониторингийг зохих журмын дагуу хийж дүн тайланг гаргаж, бүс нутаг бүрээр бэлчээрийн даац, багтаамжийг тодорхойлж зураглал гаргав. Энэ оны хувьд аймаг дундын отрын бүсэд нийт 594,3 мянган мал оруулах бэлчээрийн даацтай болох нь тогтоогдлоо. Үүнээс Хэрлэнбаян-Улаанд 297,7 мянга, Малахад 95,6 мянга, Аргалантад 20,0 мянга, Багахайрханд 65 мянга, Чойбалсанд 107,7 мянган мал өвөлжүүлэх, хаваржуулах бэлчээрийн даац, багтаамжтай байна. /Засгийн газрын тогтоолоор Хэрлэнбаян-Улааныг 2 жил өнжөөх болсон тул уг бүс тооцооноос хасагдана./
  - Засгийн газрын “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”- ийн хүрээнд эрчимжсэн саалийн үхрийн аж ахуйг өргөтгөх, малын чанарыг сайжруулах чиглэлээр Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд төсөл боловсруулж 2008, 2009 онд ирүүлсэн 209 төслийг нэг бүрчлэн шалгаж дүгнэлээ. Ажлын хэсэг ирүүлсэн төслүүдийг шалгаруулахдаа тухайн иргэн, аж ахуйн нэгж нь Засгийн газрын “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”- ийн хавсралтанд заасан бүс нутагт үйл ажиллагаа эрхлэж байгаа болон тухайн өндөр ашиг шимтэй үржлийн өсвөр үхрийг маллахад шаардагдах материаллаг бааз байгаа эсэх, тухайн үхрийг үржүүлж байсан туршлага, төслийн боловсруулалт, үр дүн, ач холбогдол зэргийг үндсэн шалгуур үзүүлэлт болгон үзсэн. Ажлын хэсэг “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”- ийн 5.2.1, 5.2.5 дахь заалтын хүрээнд энэхүү дэмжлэгт аль болох олон иргэн, аж ахуйн нэгжүүдийг хамруулах зорилгоор шалгарсан хуулийн этгээдэд 5- аас дээшгүй үхэр олгохоор санал нэгдсэн. Дээрхи үндсэн болон туслах шалгуур үзүүлэлтийг харгалзан ажлын хэсгээс нийт 45 иргэн, аж ахуйн нэгжийг сонгож үхэр олгохоор шийдвэр гаргууллаа. ХХААХҮЯ – аас зарласан тендерт шалгарсан Хэнтий аймгийн Биндэр сумын “Ган сумч” ХХК “Шар тарлан үүлдрийн үржлийн өсвөр үнээ 145 толгой, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн “Өрнөх дэвжих” ХХК “Хар тарлан” үүлдрийн үржлийн өсвөр үнээ 70 толгой үхрийг тус тус, бүгд 215 үржлийн өсвөр үхрийг нийлүүлэхээр гэрээ хийснээс 2009 оны 9 дүгээр сарын 25 – ны өдөр “Ган сумч” ХХК – аас нийлүүлэх 145 толгой өсвөр үнээг 29-н иргэн, аж ахуйн нэгжтэй нэг бүрчлэн, гэрээг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр хийж олголоо.
  - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын уламжлалт “Намрын ногоон өдрүүд-2009” нэгдсэн арга хэмжээг 9 сарын 18-24-ний өдрүүдэд Мишээл ЭКСПО төвд амжилттай зохион байгуулав. Нэгдсэн арга хэмжээнд нийслэл, хөдөө орон нутгаас нийт 550 гаруй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оролцож, эх орны үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүн, монгол нутгийн хөрсөнд ургасан төмс, хүнсний ногоо, шилмэл үүлдрийн малаа

- сурталчилж, иргэд хөдөлмөрчдөд бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэжээ. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд нийт 23 номинациар шилдэг бүтээгдэхүүн, аж ахуй нэгж, байгууллагыг шалгаруулж өргөмжлөв.
- “Нийслэлийн намрын ногоон өдрүүд-2009” арга хэмжээний хүрээнд Сэлэнгэ, Төв, Орхон, Дархан-Уул аймгийн нийт 20 гаруй сумдын ногоочдыг нийслэлийн Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн худалдааны төвүүдэд зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаанд оролцуулах хуваарилалтыг хийж Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлэв. “Нийслэлийн намрын ногоон өдрүүд-2009” арга хэмжээ үргэлжилж байна.
  - ЖДҮ-ийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр улсын төсөвт тусгагдсан 850 сая төгрөг, 30 тэрбум төгрөгийн зохих хувийг аймгуудын ЖДҮ-ийг хөгжүүлэх дэд сангуудад хуваарилан төвлөрүүлэн, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээл олгох ажлыг эрчимжүүлж байна. Үүнд:
    - Орон нутагт хуваарилагдсан эх үүсвэрээс 2009 оны 9 дүгээр сарын байдлаар аймгуудад 1133 төсөлд 13.3 тэрбум төгрөг олгогдож, зээл олголт 83%-тай байна. Улаанбаатар хотод 122 төсөлд 6.2 тэрбум төгрөг олгогдож зээл олголт 64%-тэй байна.
    - Бодлогын чанартай томоохон төслийг санхүүжүүлэх эх үүсвэрээс 2009 оны 9 дүгээр сарын байдлаар 10 төсөлд 4.51 тэрбум төгрөг олгогдож, 5.59 тэрбум төгрөгийн 12 төсөл Зээлийн хороогоор шийдвэрлэгдээд байна. 5.51 тэрбум төгрөгийн 16 төсөл судлагдаж, 1.4 тэрбум төгрөгийн 4 төсөл шийдэгдээгүй байна.
  - Говийн бүсийн аймгуудын ерөнхий боловсролын сургуулиуд болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Бизнестэй танилц” хөтөлбөрийн багш бэлтгэх сургалтыг Говьсүмбэр аймагт зохион байгуулав.

#### **Гурав. Гадаад хамтын ажиллагаа болон дотоод ажлын талаар**

- Монгол Улс, БНЧУ-ын Засгийн газар хоорондын комиссын хуралдаанд оролцож, салбарын чиглэлээр малын ээмэгжүүлэх хамтарсан үйлдвэр байгуулах боломжийг судлах асуудлыг хуралдаанаас гарах Протоколд тусгуулав. Уг хуралдаанаар Чехийн тал эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажиллах чиглэлээ тогтоогүй тул “арьс ширний үйлдвэрийн технологийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжийн техник, технологийг шинэчлэх төслийг хэрэгжүүлэх” саналыг хэлэлцүүлсэн боловч ЗГХКХ-аас гарах Протоколд тусгаагүй болно.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын БНХАУ-д хийх ажлын айлчлалын бэлтгэлийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд айлчлалын асуудлыг Засгийн газрын 09 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар оруулж хэлэлцүүлж, шийдвэр гаргуулав. Айлчлалын үеэр байгуулах “Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Хятадын ХАА-н Академи хооронд хамтран ажиллах тухай Санамж бичиг” болон “Монгол Улсын Засгийн Газар, БНХАУ-ын Засгийн газар, НҮБ-ын ХХААБ хооронд Өмнөд, Өмнөдийн хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажиллах 3 талт хэлэлцээр” баримт бичгүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, бэлэн болгов.
- “Монгол Улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө буюу манай талаас угтуулан тавьж болохуйц хэлэлцээний нөхцөлд ХХААХҮ-ийн чиглэлээр тусгах саналыг боловсруулж 1/3069 тоот албан бичгээр ГХЯ-нд хүргүүлэв.
- БНСУ-ын Хөдөөгийн хөгжлийн удирдлагын газраас Азийн хүнс, хөдөө аж ахуйн хамтын ажиллагааны санаачилгад Монгол Улсын нэгдэн орох тухай Санамж бичгийн төсөл боловсруулж холбогдох яамдаас санал авахаар ажиллаж байна.

#### **ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**